



## МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 9 дугаар  
сарын 30 өдөр

Дугаар

А. 81/4

Улаанбаатар  
хот

"Сургалт үйлдвэрлэл халамжийн төв",  
"Хүүхэд хамгаалал төв"-ийн бүтэц үйл  
ажиллагааг нэгтгэн зохион байгуулах  
тухай

1. "Сургалт үйлдвэрлэл халамжийн төв", "Хүүхэд хамгаалал төв"-үүдийн бүтэц үйл ажиллагааны давхардлыг харгалзан нэгтгэсэн зохион байгуулалтанд оруулж Нийслэлийн засаг даргын Тамгын газрын дэргэд "Хөдөлмөр хүмүүжил-сургалтын төв" болгон ажиллуулсугай.

2. "Хөдөлмөр хүмүүжил-сургалтын төв"-ийн дүрмийг 1 дүгээр хэвсрэлтээр, орон тоо бүтцийг 2 дугаар хэвсрэлтээр тус тус баталсугай.

3. "Хөдөлмөр хүмүүжил-сургалтын төв"-ийн захирлаар Пунцаг овогтой Оюуныг 1999 оны 10 дугаар сарын 8-нээс томилж сарын үндсэн цалинг 40.000 төгрөгөөр тогтоосугай.

4. "Хөдөлмөр хүмүүжил-сургалтын төв" байгуулагдсантай холбогдуулан "Сургалт үйлдвэрлэл халамжийн төв", "Хүүхэд хамгаалал" төвийг 1999 оны 10 дугаар сарын 1-ээр тасалбар болгон татан буулгасугай.

5. Дээрх хоёр төв татан буугдсантай холбогдуулан тус газруудын үндсэн хөрөнгийг (Сургалт үйлдвэрлэл халамжийн төвийн байрнаас бусад) шинээр зохион байгуулагдаж байгаа "Хөдөлмөр хүмүүжил сургалтын төв" д балансаас балансад шилжүүлэхийг Нийслэлийн Өмчийн газар (н.Буянмөнх), нүүлгэн суурьшуулахыг (хуучнаар Хүүхэд хамгаалал төвийн байранд) Нийтлэг үйлчилгээний газар (н.Дашням), зохион байгуулалтын ерөнхий зохицуулалт хийхийг Нийгмийн бодлогын хэлтэс (н.Хадхүү)-д тус тус үүрэг болгосугай.

6. Сургалт үйлдвэрлэл халамжийн төвийн захирлаар ажиллаж байсан н.Түмэнбуян, Хүүхэд хамгаалал төвийн захирлаар ажиллаж байсан н.Шижирбаатар нарыг бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 1999 оны 10 дугаар сарын 1-нээс ажлаас чөлөөлсүгэй.

Дээрх хоёр байгууллагын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дарваах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга  
Гишүүд

Д.Хадхүү НЗДТН-ын НБХ-ийн дарга  
С.Солонго Сагхүүгийн хэлтсийн мэргэжилтэн  
Б.Лхамсүрэн НБХ-ийн мэргэжилтэн  
А.Элбэгсайхан Өмчийн газрын мэргэжилтэн  
н.Оюунсүвд Өмчийн газрын мэргэжилтэн

8. "Сургалт үйлдвэрлэл халамжийн төв", "Хүүхэд хамгаалал төв"-ийн энэ онд батлагдсан төсөвт багтаан Хөдөлмөр хүмүүжил –сургалтын төвийг санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс (н.Гонгор)–т даалгасугай.

9. Хүүхэд хамгаалал төвийн үндсэн хөрөнгө болох "Од" зусланг "Хөдөлмөр хүмүүжил–сургалтын төв"-ийн балансад шилжүүлэхийг Нийслэлийн Өмчийн газар (н.Буянмөнх), Хүүхдийн хөдөлмөр амралтын зуслан болгон ажиппуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (н.Хадхүү)–т тус тус үүрэг болгосугай.

10. "Хөдөлмөр хүмүүжил–сургалтын төв"-ийн харуул хамгаалалт, хяналт зохицуулалтанд зориулж Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхдийн хаяг тогтоох тасгийн одоогийн орон тоон дээр хүүхдийн байцаагчийн ( Офицер –1, цагдаа –6 гурван ээлжээр ажиллах ) орон тоог нэмж төсвийн санхүүжилт хийхийг Санхүүгийн хэлтэс (н.Гонгор)–т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

A long, flowing handwritten signature in black ink, extending from the center towards the right side of the page.

М.ЭНХБОЛД